

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.01.07-01.11

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 3 долоо хоног дараалан өслөө. "Boeing" компанийн хувьцааны ханш өссөнөөр S&P 500 индексийн сагсанд багтдаг аж үйлдвэрийн салбарын компаниудын ханш, мөн газрын тосны үнэ нэмэгдсэнээр эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш тус тус өсчээ. Харин санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

БНХАУ, АНУ хоорондын дунд түвшний худалдааны хэлэлцээр Даваа гарагт эхэлсэн билээ. Мягмар гарагт АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп хэлэлцээр амжилттай яваа талаар мэдээлж, хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн байна.

АНУ-ын Засгийн газрын үйл ажиллагаа санхүүжилтгүйн улмаас хэсэгчлэн саатаад 3 долоо хонож байгаа ч хөрөнгө оруулагчид энэ асуудалд эерэг хүлээлттэй байгаа аж. 12-р сард ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргагчдийн тоо тогтвортой байсан бол бичил бизнесийн итгэлцлийн үзүүлэлт урьдчилан таамагласнаас бага хэмжээгээр буурчээ.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлснээр хэрэглээний үнийн индекс таамаг хэмжээнд өссөн байна. Суурь инфляцийн түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2%-аар өсчээ. "АНУ-ын Төв банк бодлогын хүүг өөрчлөх шийдвэртээ хүлээцтэй хандах зорилгоор зорилтот инфляцийн түвшинг бууруулна" гэж тус банкны тэргүүн Жером Пауэлл мэдэгдсэн.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээр эхэлснээр Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Харин Герман болон Франц улсын эдийн засгийн удаашрал, Европын авто машин үйлдвэрлэгчдийн ажлын байрны орон тооны цомхотгол зэрэг үйл явдал хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

Их Британи Европын Холбооноос гарах "Brexit" хэлэлцээр 3-р сарын 29-ний өдрөөс хойшилж магадгүй болсонтой холбоотойгоор фунтийн ханш ам.долларын эсрэг 1%-аар чангарчээ. 1-р сарын 15-ны өдөр Их Британийн Парламент тус улсын Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйн барьсан "Brexit" хэлэлцээрийн төслийг хэлэлцэн батлах юм. Гэсэн хэдий ч тус төсөл батлагдахгүй гэсэн хүлээлт шинжээчдийн дунд давамгайлж байгаа ажээ.

"Ford Motor" компани Европын зах зээл дэх бизнестээ шинэчлэлт хийн, хэдэн мянган ажлын байрны цомхотгол хийж байгаа талаар мэдээлснээр тус компанийн хувьцааны ханш буурчээ. Мөн "Jaguar Lan Rover" компани Их Британи дах үйлдвэрийнхээ 4,500 ажлын байранд цомхотгол явуулахаар төлөвлөж байгаа талаар мэдээлэв. "Honda" компани "Brexit" хэлэлцээрийн тодорхойгүй байдалтай холбоотойгоор Их Британи дахь үйлдвэрийнхээ үйл ажиллагааг 6 хоногийн турш зогсоож байгаа аж.

11-р сард ХБНГУ-ын экспорт буурч, тус улсын эдийн засгийн өсөлт удааширч байгааг илтгэх болжээ. Мөн тус улсын аж үйлдвэрлэлийн гарц болоод аж үйлдвэрийн бүтээгдэхүүний захиалгын хэмжээ 2 сар дараалан унав. Франц улсын авто машин, тоног төхөөрөмж, эм болоод бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн аж үйлдвэрлэлийн гарц буурчээ. 2018 оны 11-р сарын дунд үеэс эхэлсэн "шар хантаазтангуудын" бослого тус улсын эдийн засгийн өсөлт удааших гол шалтгаан болжээ.

Япон: Японы Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 11-р сард тус улсын бодит цалингийн түвшин 4 сар дараалан буурсны эцэст өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.1%-аар өсчээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,531.32	-0.84% ▼
Dow Jones	АНУ	23,995.95	2.40% ▲
S&P 500	АНУ	2,596.26	2.54% ▲
Nasdaq	АНУ	6,971.48	3.45% ▲
S&P/TSX	Канад	14,939.18	3.55% ▲
FTSE 100	Их Британи	6,918.18	1.18% ▲
S&P/ASX 200	Австрали	5,774.60	2.76% ▲
Nikkei 225	Япон	20,359.70	4.08% ▲
Hang Seng	Хонг Конг	26,667.27	4.06% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.16
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	96.16
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	95.21
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.73
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.75
DBM' 2023	USD	7.250%	98.39
TDBM' 2020	USD	9.375%	104.25

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.500	-0.02 ▼
Libor 3M	2.780	-0.02 ▼
Libor 6M	2.840	-0.02 ▼
Libor 1YR	3.010	0.05 ▲
US 2YR Bond	2.541	0.04 ▲
US 3YR Bond	2.516	0.04 ▲
US 5YR Bond	2.529	0.03 ▲
US 10YR Bond	2.701	0.03 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.01.11	Өөрчлөлт
USD	2,666.14	0.59% ▲
CNY	395.17	2.35% ▲
EUR	3,072.86	1.63% ▲
RUB	39.83	2.76% ▲
KRW	2.39	1.27% ▲
JPY	24.61	0.12% ▲
CAD	2,019.96	2.49% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,291.93	0.13% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.64	-0.70% ▼
Зэс	USD/lb.	266.00	0.49% ▲
Нүүрс	USD/MT	97.75	-1.26% ▼
WTI газрын тос	USD/bbl.	51.66	5.97% ▲
Brent газрын тос	USD/bbl.	60.53	4.54% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	3.31	11.82% ▲

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XI	8.10%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XI	10.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	12.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XI	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	17.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XI	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 44 компанийн 549.8 сая төгрөгийн 2,454,126 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 16.27%-аар буюу хамгийн ихээр өсч 1,029 төгрөгт хүрч хаагдсан бол “Дархан хөвөн” /DAH/ компанийн хувьцаа 30.77%-аар буурч 9,000 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


1-р сарын 11-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,496.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,531.32 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.84%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	549.8
Зах зээлийн үнэлгээ	2,496,165.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,531.32	-0.84% ▼
MSE I индекс	10,064.71	-1.48% ▼
MSE II индекс	8,781.52	0.23% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	401,138	140,403,219
АПУ	198,310	125,252,193
ЛэндМН ББСБ	1,410,543	100,113,743
Сүү	248,870	51,136,081
Ард даатгал	54,638	39,931,118

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	1,029.00	16.27% ▲
Эрчим баян өлгий	600.00	13.42% ▲
Дархан зочид буудал	95.00	5.56% ▲
Ремикон	29.00	5.45% ▲
Дөрвөн-Уул	1,350.00	3.85% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан хөвөн	9,000.00	30.77% ▼
Нийслэл өргөө	5,300.00	26.64% ▼
Булган гурил тэжээл	1,360.00	-15.00% ▼
Могойн гол	6,100.00	-14.98% ▼
Монноос	2,200.00	-12.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Би Ди Сек	342,255,003
Мирэ Эссет Секьюритис Монгол	150,899,279
Ард секьюритиз	107,972,056
Голомт Капитал	107,301,061
Бумбат-Алтай	81,784,520

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	622.78	662,751
Таван толгой	7,120.00	374,976
МИК Холдинг	14,750.00	305,462
Говь	351.08	273,882
Сүү	207.04	71,222

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж буй 2019 оны анхны компани болох “Түмэн шувуут” ХК нь нийт хувьцааныхаа 25 хувь буюу 50 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн сурталчилгааг эхлүүлээд байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авах бөгөөд худалдан авах захиалгыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу тогтсон үнийн аргаар авах юм.

Нийтэд санал болгож буй хувьцааны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд суурь хуваарилалт буюу нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваан олгох дүнг 3 тэрбум төгрөгөөр тооцож, үлдэх 7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хоёр их наяд 530 тэрбум төгрөг даваад байна

1-р сарын 10-ны байдлаар дотоодын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ хоёр их наяд 530 тэрбум төгрөгийг даваад байна. Үүний 80 орчим хувийг “Топ 10” компани бүрдүүлж байгаа юм.

Зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч 10 компанийн долоо нь I ангиллын, гурав нь II ангиллын компаниуд байна. Энэ дундаас “ЛэндМН”, “Мандал даатгал” зэрэг хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүнүүд “Топ 10”-т шинээр нэмэгдсэн нь олны анхаарал татаж байгаа юм. Харин энэхүү жагсаалтыг АПУ компани дахин тэргүүллээ. АПУ компанийн зах зээлийн үнэлгээ 2017 оны 12 дугаар сард буюу нэгдлийн дараа 960 тэрбум төгрөгийг давж байсан юм. Өөрөөр хэлбэл дотоодын хөрөнгийн зах зээлд нэг их наяд төгрөгөөр хэмжигдэх анхны компани болоход ойрхон байжээ.

Харин үүнээс хойш жил гаруйн хугацаанд тус компанийн хувьцааны ханш 30 орчим хувиар унаж, улмаар зах зээлийн үнэлгээ нь 679 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Үүний дараа “Тавантолгой” компани 384.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэйгээр жагсаалтын хоёрдугаарт бичигдэж байгаа юм. “Тавантолгой” компанийн хувьцааны ханш 2018 оны 3-р сард 700 тэрбум төгрөгт хүрч дотоодын хөрөнгийн захад зах зээлийн үнэлгээгээр тэргүүлж байв. Тухайн үед нүүрсний гарц нэмэгдэх хүлээлттэй холбоотойгоор хувьцааны ханш нь 13 мянган төгрөгийг даваад байжээ. Хэдий тийм боловч одоо үнэлгээнийхээ талыг алдаад байна гэж хэлж болохоор байна.

АПУ, “Тавантолгой” компанийн дараа “МИК холдинг”, “Говь” компаниудын үнэлгээ гурван оронтой тоогоор хэмжигдэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

СЗХ: Шинээр гаргах хувьцааг бүртгэж, багц дүрмүүдийг баталлаа

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны анхны ээлжит хуралдаанаа 2019 оны 1-р сарын 9-ны өдөр хийж, Даатгалын болон Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрмүүдийг хэлэлцэн баталлаа. Даатгалын багц дүрэмд тусгай зөвшөөрлийн, нөхцөл шаардлага, шалгуур үзүүлэлтийн, төлбөрийн чадварын, нөөцийн болон бусад сангийн, ил тод байдал, тайлагналын, хяналтын, хариуцлагын зэрэг 17 дүрэм, журам, аргачлал, заавар багтаж байгаа бол Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм нийт 14 зохицуулалтын актаас бүрдэж байна. Эдгээр багц дүрмүүдээр даатгалын болон үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг эрхэлж буй хуулийн этгээдүүдэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх, үүнтэй холбогдон тэдгээрт тавигдах шаардлага, шалгуурыг тогтоох, үйл ажиллагаанд тавих, дагаж мөрдөгдөх хяналт, зохицуулалт, мөн тэдгээрийн дотоод үйл ажиллагаа, мэдээлэл, тайлагналын асуудал, татан буулгах дахин хөрөнгөжүүлэх болон зар сурталчилгаанд тавих хяналт зэрэг цогц харилцааг нийтэд нь зохицуулах юм.

Хуралдаанаар, “Ард кредит ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 280 сая ширхэг хувьцааг бүртгэж, үүний 25 хувь буюу 70 сая ширхэгийг нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө. Энэ нь үнэт цаасаа нийтэд санал болгон гаргаж буй хоёр дахь банк бус санхүүгийн байгууллага болж байна.

Мөн хуралдаанаар, “Ард даатгал” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орууллаа. Түүнчлэн “Дэвжих хөгжил ББСБ”, “Хөгжих капитал ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай асуудлуудыг хэлэлцэн зөвшөөрч, “Заг чандмань ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүллээ.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Ард кредит ББСБ” компани нээлттэй хувьцаат компани боллоо

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 11-р сарын 30-ны өдрийн А/133 тоот тушаалаар “Ард Кредит ББСБ” ХК-ийн нийт 280,000,000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн II ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 03 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 70 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг олгосон байна.

Тус компани олон нийтэд арилжаалах хувьцааны 50 хувь буюу 35 сая ширхэгийг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар буюу нэгжийн үнийг 70 төгрөгөөр, үлдсэн 50 хувь буюу 35 сая ширхэгийг захиалгын бүртгэлийн аргаар нэгжийн үнийг 70-85 төгрөгөөр нийтэд санал болгон худалдаж, нийт 4.9-5.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй бөгөөд үүнийг зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зарцуулах юм.

Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг “Ард Капитал групп ҮЦК” ХХК, аудитын үйлчилгээг “Далай Ван Аудит” ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг “Өмгөөллийн И Эл Си” ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг “БДО Аудит” ХХК тус тус үзүүлж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2019 онд олборлолтоо эхлүүлэх алтны 21 төслийн ТЭЗҮ баталжээ

2019 онд хэрэгжүүлж эхлэхээр ТЭЗҮ-ээ батлуулсан алтны 21 төсөл байгаа талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ. Энэ дундаас хамгийн их хөрөнгө оруулалттай төслүүдийг дурдвал Өмнөговь аймгийн нутагт байрлах “Хоримт худаг”, “Улаан хяр” алтны үндсэн ордын төсөл байна. “Макс импекс” ХХК энэхүү төслийн нийт хөрөнгө оруулалтыг 10.5 тэрбум төгрөг байхаар ТЭЗҮ-д тусгажээ.

Үүнээс гадна Дорноговь аймагт байрлах Шартолгойн алтны үндсэн ордын төсөл байгаа юм. Нийт хөрөнгө оруулалтыг нь 9.2 орчим тэрбум төгрөг байхаар ТЭЗҮ-д нь тусгасан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ. Мөн байршлаар нь харвал Баянхонгор аймагт хамгийн олон буюу алтны есөн төсөл энэ онд хэрэгжиж эхлэхээр ТЭЗҮ-ээ батлуулжээ. Алтны шороон ордуудын нөөц дуусах шатандаа орж байгаа бөгөөд цаашид хөрөнгө оруулалт их шаардагддаг үндсэн ордуудын олборлолт эхлэх төлөвтэй байгаа гэдгийг салбарынхан онцолж байгаа юм.

Эдгээрээс гадна гаднын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хайгуулын компаниуд алтны ордуудынхаа олборлолтыг эхлэхээр бэлтгэж байна. Тухайлбал, “Steppe Gold” компани Дорнод аймгийн нутагт байрлах Алтан Цагаан овоо ордынхоо олборлолтыг 2019 оны эхний хагас жилд эхлэхээр бэлтгэж байгаа аж. “Triple Flag” компанитай байгуулсан гэрээний хүрээнд Алтан Цагаан овоо төслийн бүтээн байгуулалтын 8.1 сая ам.долларын зардлыг санхүүжүүлсэн байна.

Монгол, Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Erdene Resource Development” компани “Хөндий” төслийнхөө олборлолтын тусгай зөвшөөрлийг авахаар бэлтгэж байна. Баянхөндий, Алтан нар ордуудыг багтаасан энэхүү төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Ч.Хашчулуун: Махны экспорт дотоодын махны үнийг өсгөнө

2018 онд Монгол Улс 83 сая ам.долларын мах, 80 орчим сая ам.долларын лаазалсан мах, хиам, зайдас экспортолжээ. Махны экспорт өмнөх оны мөн үеэс 54 хувиар өссөн бол дулааны аргаар боловсруулсан мах буюу лаазалсан мах, хиам зайдасны экспорт өмнөх оны мөн үеэс ес дахин өссөнийг Гаалийн ерөнхий газрын статистикаас харж болохоор байна.

2018 оны эхний 11 сард махны үнэ төрлөөсөө хамаарч өмнөх оноос 15.5-31.6 хувь хүртэл өссөн гэж Үндэсний статистикийн хороо мэдээлээд байгаа юм. Монголбанк 11-р сард Улаанбаатарын инфляци 9.3 хувь хүрсний 1.3 нэгж хувийг махны үнийн өсөлт бүрдүүлсэн гэж мэдээллээ. Махны үнэ монгол хүний хэрэглээний сагсны 10 орчим хувийг дангаараа бүрдүүлж байгаа юм. Хаврын улиралд суурин газарт махны нийлүүлэлтийн хомсдол үүсдэгтэй холбоотой нөөцийн мах бэлтгэх зээлийн хөнгөлөлтөд зориулж 2019 оны төсөвт 4.6 тэрбум төгрөг суулгасан гэж ХХААХҮЯ мэдээллээ. Энэ хүрээнд 10 мянган тонн мах нөөцлөх боломжтой гэж үзэж байна. Нөгөө талаас экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой мах үйлдвэрлэгчдийн дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Дотоодын хэрэгцээнд жилд дунджаар 12-15 сая толгой мал хэрэглэдэг. Хүн амын дотоодын махны хэрэгцээг бүрэн хангаад, цаашид есөн сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, нийт 180 гаруй мянган тонн мах экспортлох боломжит нөөц Монгол Улсад байгаа гэж ХХААХҮЯ мэдээлж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ВI: БНХАУ-д үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт саарч, коксжих нүүрсний ханш унах төлөвтэй

2019 онд БНХАУ-д шинээр эхлүүлэх үл хөдлөх хөрөнгө, бүтээн байгуулалтын ажил цөөрснөөр гангийн эрэлт буурах төлөвтэй байна. Энэ нь барилгын салбарын гол түүхий эд болох коксжих нүүрсний ханшид ч сөргөөр нөлөөлөхөөр байгаа ажээ.

“Bloomberg Intelligence”-ийн судалгаагаар макро хүчин зүйлээс гадна БНХАУ-ын Засгийн газрын төлөвлөгөөний тааруу хэрэгжилт гангийн эрэлтийг бууруулж байгаа юм. Тухайлбал, шинэ барилга барих зорилгоор хэрэгжүүлж буй газар чөлөөлөх ажиллагаа удааширсан байна. БНХАУ 2014-2020 онд хотын бүс дэх ядуусын хорооллын барилгыг нурааж, шинэ барилга барих талаар хотжилтын төлөвлөгөөндөө тусгажээ. Гэсэн хэдий ч орон нутгийн захиргаа газар чөлөөлөх ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж чадахгүй байгаа юм. Мөн түр нүүлгэн шилжүүлэх шаардлагатай иргэдэд халамжийн мөнгө олгох, барилгын ажилд татаас олгох зэрэгт их хэмжээний хөрөнгө шаардах болжээ. Арилжааны банкнууд энэ чиглэлд зээл олгохоо больсон нь газар чөлөөлөх ажлыг удаашруулжээ. Судалгаанд оролцсон шинжээчдийн таамгийг дундажлахад энэ онд эрэлт буурснаар коксжих нүүрсний ханш зургаа орчим хувиар унаж, 178 ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Коксжих нүүрсний нийлүүлэлт нэмэгдсэнээр 15 сая тонны илүүдэл үүсэх хүлээлттэй байна. Энэтхэг, Бразил болон Зүүн Өмнөд Азид нүүрсний эрэлт өсч байгаа ч гол худалдан авагч БНХАУ-ын эрэлт буурна гэж шинжээчид тооцоолжээ. Экспорт талдаа Австралийн нийлүүлэлт хамгийн их буюу найман сая тонноор, “Mechel” уурхайн гарц нэмэгдсэнээр ОХУ-ын экспорт гурван сая тонноор тус тус өсөх төлөвтэй байна.

Харин Монголын тухайд нүүрсний экспорт өсөхөд хилийн нэвтрүүлэх хүчин чадлын хязгаар тушаа болно гэж Лондон дахь “Bloomberg”-ийн шинжээчид дүгнэлээ. Дунд хугацаанд Энэтхэг болон Азийн орнуудын өсөн нэмэгдэж буй коксжих нүүрсний хэрэгцээний дийлэнхийг ОХУ, Австрали улс хангахаар байгаа аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

Гашуунсухайт боомтоор 1/07-нд нүүрс тээврийн 164 автомашин гарчээ

Даваа гарагт Гашуунсухайт боомтоор нүүрс тээврийн 164 автомашин гарсан бол өнгөрсөн Бямба гарагт 165 автомашин экспорт хийсэн байна. 11-р сард БНХАУ-ын тал ухаалаг систем нэвтрүүлж байгаатай холбоотойгоор экспорт огцом буурсан ч 12-р сар гарсны дараа эргэн сэргэсэн юм. Улмаар 12-р сарын эцсээр 500-600 автомашин нүүрс өдөрт экспортолж байсан юм. Монгол Улсын хувьд 2018 онд нийт 36 сая гаруй тонн нүүрс экспортолсон талаар эх сурвалж мэдээллээ. 2018 онд Гашуунсухайт-Ганцмод боомтын нүүрсний экспорт нэг сая тонноор нэмэгдэж, 18.2 сая тонн болсон байна. Харин Шивээхүрэн-Сэхэ боомтын экспорт 1.4 сая тонноор нэмэгдэж, 14.1 сая тонн болжээ.

Үүнээс гадна Замын-Үүд-Эрээний боомтоор төмөр замаар 1,800 мянган тонн нүүрс экспортолсон нь 2017 оныхоос 450 мянган тонноор нэмэгдсэн байна. 2019 онд нүүрсний экспортоо 42 сая тоннд хүргэх зорилтыг Засгийн газар тавьсан бөгөөд үүнд хүрэхэд гаалийн шинэчлэл чухал гэж Сангийн яам үзэж байгаа аж. Энэ хүрээнд хилийн боомтуудад эрдэс бүтээгдэхүүн, газрын тос, автобензин, дизель түлшний төрөлжсөн лабораториудыг үе шаттай байгуулахаар төлөвлөсөн байна. Мөн гаалийн лабораторийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг ажил хийх юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Импорт дунджаар 40 хувиар өссөн 2018 онд гадаад худалдааны ашиг 1.1 тэрбум ам.доллар болж буурав

2018 оны 12-р сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 12.8 тэрбум ам.доллар хүрч, өмнөх жилийн гүйцэтгэлээс 22.3 хувиар өссөн гэж Гаалийн ерөнхий газар мэдээллээ.

Энэ хугацаанд экспорт 13.1 хувиар өссөн бол импорт илүү хурдацтай буюу 35.5 хувиар өссөн байна. Импортын хурдтай өсөлт гадаад худалдааны тэнцлийн ашиг 1.1 тэрбум ам.доллар болж буурахад нөлөөллөө. 2017 оны мөн үед 1.8 тэрбум ам.долларын ашигтай гарч байсан худалдааны тэнцэл 2018 онд 1.1 тэрбум ам.доллар болж буураад байгаа юм. 2018 оны хувьд нүүрсний экспорт 11-р сарын байдлаар өмнөх жилийн эцсийн гүйцэтгэлээ давжээ. Харин 2019 онд Засгийн газраас 42 сая тонн нүүрс экспортлох зорилго тавиад байна. Энэ хүрээнд хийх гаалийн шинэчлэлийн үр дүнд Гашуунсухайт-Ганцмодны боомтоор гарах автомашины тоо одоогийнхоос хоёр дахин өсч, өдөрт 2000 давах боломжтой гэж Гаалийн ерөнхий газар мэдээлсэн юм.

Нөгөө талаас импорт оны эхнээс 40 орчим хувиар өсчээ. Импортын дийлэнхийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн орц эзэлж байгаа гэж Төв банк мэдээллээ. Монголбанк өсөн нэмэгдэж буй импортыг хязгаарлах, валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогын шийдвэрүүд гаргаж, 2019 оны 1-р сараас хэрэгжүүлж эхэлсэн юм.

Үүнээс гадна “Монгол Улсад гадаад худалдааны бодлого хариуцсан агентлаг хэрэгтэй” гэж эдийн засагч Н.Энхбаяр онцолж байв.

Мөн гадаад худалдааны бараа эргэлтийн өсөлтийн талаар Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар “Одоо ч байдал эмзэгдүү байгаа. Гэхдээ бид улс үндэстний хувьд багийн зарчмаар гадаад бодлогынхоо тавцанд ажиллаж чадсан тул дээрх үр дүнд хүрсэн” гэж мэдэгдэж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Дэлхийн банк: Хөгжиж буй улсуудын өрийн эмзэг байдал нэмэгдсэн

Дэлхийн банк 2019 оны өсөлтийн таамгийг хагас жилийн өмнө танилцуулж байснаас 0.1 хувиар бууруулж, 2.9 хувь болгоод байна. Худалдааны өсөлт болон хөрөнгө оруулалт саарч, Төв банкнууд бодлогын хүүгээ өсгөж байгаа энэ үед Дэлхийн банк 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамгаа бууруулж тогтоолоо. Ялангуяа хөгжиж буй эдийн засагтай улсуудын хувьд өрийн эмзэг байдал нэмэгдсэнийг онцолж байна.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд 6.6 хувиар, ирэх 2020 онд 6.3 хувиар өснө гэсэн таамгийг Дэлхийн банк дэвшүүлсэн байна. Монгол Улсын харьяалагдаж байгаа Зүүн Ази болон Ази, Номхон далайн бүс нутагт энэ жил болон ирэх онуудад тулгарч болох гол эрсдэлийг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, худалдаа хумигдаж байгаатай холбон тайлбарласан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Eurasia: 2019 оны хамгийн том эрсдэл геополитикийн асуудал

“Eurasia” группээс 2019 онд олон улсад тулгарах хамгийн гол эрсдэлээр геополитикийн асуудлыг нэрлэсэн байна. Дэлхийн хамгийн том эдийн засагтай хоёр орны хооронд өрнөж байгаа худалдааны маргааныг 2019 оны гол эрсдэл гэж “Eurasia” групп үзжээ.

Худалдааны маргааны асуудлаар АНУ, БНХАУ хэзээ зөвшилцөлд хүрч, “Худалдааны дайн” зогсох нь тодорхойгүй байна. Гэхдээ “Их 20”-ийн уулзалтын үеэр хийсэн 90 хоногийн түр хугацааны зөвшилцөл нь урт хугацаанд хэлцэлд хүрэх зам болно гэж шинжээчид үзэж байна. Ерөнхийдөө “Худалдааны дайн”-аас хөгжингүй, томоохон орнууд давуу тал хүртэх бол харьцангуй жижиг орнуудын хувьд эсрэгээрээ алдагдал хүлээнэ гэж шинжээчид тайлбарлаж байгаа юм. АНУ, БНХАУ-ын худалдаа буурахтай зэрэгцээд томоохон орнуудад худалдаа нэмэгдэх боломжтой бол худалдаанаас өндөр хамааралтай жижиг улсуудын хувьд энэ нөхцөл хязгаарлагдмал байдаг байна.

Цаашид маргаан даамжирч, эдийн засагт тодорхойгүй байдал нэмэгдвэл 2021 он гэхэд дэлхийн эдийн засгийн өсөлт 0.8 хувиар саарах эрсдэлтэй гэж Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага таамаглажээ. Түүнчлэн АНУ-ын улс төрийн байдал, Засгийн газрын дотоод зөрчил томоохон эрсдэл болох юм байна.

Үүнээс гадна 2019 онд цахим халдлага ширүүснэ гэж “Eurasia” групп үзжээ. Цахим халдлага өмнө байгаагүйгээр эрчимжих хандлагатай байгаа учраас АНУ цахим орчны хамгаалалтаа сайжруулахаар ажиллаж байгаа аж.

Түүнчлэн Европт BREXIT-ийн асуудлаас үүдэн тодорхойгүй байдал үүсч, бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж эхлээд байна. Их Британи Европын Холбооноос хэлэлцээр хийхгүйгээр гарах магадлал өндөр байгаа юм. BREXIT-ийн хэлэлцээрийн төслийг Европын Холбоо дэмжсэн боловч Их Британийн Парламент дэмжихгүй байх магадлал өндөр байна. Хэрвээ Их Британи Европын Холбооноос хэлэлцээр хийхгүйгээр гарвал Их Британийн эдийн засгийн өсөлт саарч, үл хөдлөх хөрөнгө, үйлдвэрлэл зэрэг салбаруудад бууралт гарах эрсдэлтэй байгаа юм.

Үүнээс гадна энэ оны 5-р сард болох Европын Парламентын сонгуульд популист үзэл баримтлалтай улс төрчдийн суудлын тоо нэмэгдэж, Европын Парламентын 37 хувийг бүрдүүлэх урьдчилсан тооцоог “Eurasia” групп хийсэн байна. Энэ нь Европын Парламент улс төр, эдийн засгийн цаашдын бодлогоо тодорхойлж, нэгдсэн шийдэлд хүрэхэд сорилт болно гэж шинжээчид үзэж байна.

Мөн 2019 онд ОХУ, Украины хоорондох хурцадмал байдал даамжрахгүй гэж үзжээ. Украинд ирэх 3-р сард болох Ерөнхийлөгчийн сонгууль, намар болох Парламентын сонгуульд ОХУ хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого хийж магадгүй гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.